



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 5/75

Хэрлэн сум

Б.Должинг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.10, Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, 24.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга Б.Должингийн тэтгэвэр тогтоолгох хүсэлтийн дагуу 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн ажлаас чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Ж.Гантулга

-Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн дарга

Гишүүд:

С.Оюун-Эрдэнэ

-Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн мэргэжилтэн

Н.Хашхүү

-Стандарт, хэмжил зүйн хэлтсийн
мэргэжилтэн

3. Б.Должинд ажилласан хугацааны цалингийн болон бусад тооцоог хийж дуусгахыг Стандарт, хэмжил зүйн хэлтсийн нягтлан бодогч, ажил хүлээлцүүлсэн тухайгаа 2017 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА